

**6 дугаар ангийн монгол хэл, бичиг, уран зохиолын
анги дэвших шалгалтын блупринт**

ТМТ	энгийн түвшин			ТМТ		бүтээх түвшин	
	ойлгох	сэргээн санах	хэрэглэх	задлан шинжлэх	үнэлэх	бүтээх	нийт
уншиж ойлгох чадварын түвшин, хэлний зүй		1	1				2
үг		1	1				3
өгүүлбэр	1		1	1			4
эх	1		1	1	1		
бичих чадварын түвшинд						1	1
Үндэсний бичиг	1	1					2
нийт	20%	10%	30%	20%	10%	10%	100%

Анги дэвших шалгалтын жишиг даалгавар

Хичээлийн нэр: Монгол хэл бичиг, уран зохиол

Анги: 6 дугаар анги

Хугацаа: 60 минут

Нийт - 40 оноо

Эхийг уншиж, даалгаврыг гүйцэтгээрэй.

Цэцэгсийн хувилбар

Нойрон дунд ээж “Миний хүү босоорой” гэнэ. Энэ дуу бүүр холоос дэн дун сонсогдоно. Сэрж ядах ахуйд зэлэн дээр тугал мөөрөх, чөдөртэй морь ногоо шир шир зулгаах анир тун тод. Аав аль хэдийн адуундаа явжээ.

Тоонон цамхраагаар үүрийн шаргал тэнгэр дуниартах нь сүү нь ихэдсэн ээжийн гарын цай шиг амуй. Би ухасхийн босож гадаа гарна. Үхэр тэртээх нугад идээшилнэ. Тэр зүг цэцгэн дундуур дэгдэхүйеэ, хөлийн улнаас гижиг хүрч юу юугүй л чанга чангаар инээмээр болмуй. Шүүдрийн усанд шалдан шалба норно.

Би хөв хөх манан дунд хөвж явах шиг. Эрээн цэцгүүд өнгө өнгийн алчуур зангидсан үзэсгэлэнт охид шиг толгой дохин хоцорно. Миний дэргэдүүр хоёр ангир ганганан өнгөрнө. Дээш харвал тэртээх тэнгэрийн зайнаа ганц од улаан цэцэг шиг дэлгэрэн байв. Од – цэцэг ажээ. Олж харсан шинэ нээлтэдээ урамшин улам хурдан гүйхээр тонгойтол нугаар дүүрэн шүүдэр – цэцэг. Хөл хүрүүт л бутарч унах хөх усан бөмбөлөг бас л цэцэг ажаам. Ерөөс ертөнц өөрөө мөнхийн цэцэг, сая дээгүүр өнгөрдөг хоёр ангир, тэнгэрт дэлгэрсэн гал шаргал цэцэг гэж бодоод баярлан дэвхцэв.

Хамаг биеийг нэг л жигтэй эзэмдэн, уулын нугад би цэцэг мэт урган байв.

(Дан. Нямаа, Монгол хэл – 6, УБ 2014 он, 137-р тал)

Нэгдүгээр хэсэг: Унших

1. Үгсийн утгыг тайлбарлаарай. (3 оноо)

Үгс	Эхийн жишээ баримтаар холбон тайлбарлах	Үгсийн утгыг тайлбарлах
зэл		
тооно		
цамхраа		

2. Хүү яагаад ухасхийн боссон бэ? (2 оноо)

.....
.....
.....
.....

3.“ **Од – цэцэг ажээ.** “ гэдгийг олж харсан хүүгийн нээлтийн учир шалтгааныг олж тайлбарлаарай. (2 оноо)

.....
.....
.....
.....

4. Эхээс цэцэгтэй холбоотой дүрслэлийг ялган, 5 холбоо үг бичээрэй. (2 оноо)

.....
.....
.....
.....
.....

5. Эхээс төрсөн мэдрэмж, сэтгэгдлээ илэрхийлэн бичнэ үү. (3 оноо)

.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....

Хоёрдугаар хэсэг: Хэлний зүй

6. Эхээс тусах ба эс тусах үйл үгийн жишээ тус бүр хоёр хоёрыг олж, хүснэгтэд тайлбарлан бичээрэй. (2 оноо)

Үйл үг	Эхээс тусах, эс тусах үйл үгийн жишээ тус бүр хоёрыг олж бичээрэй
Тусах үйл үг
Эс тусах үйл үг

7. **Үхэр тэртээх нугад идээшилнэ** гэсэн энгийн өгүүлбэрээс 2 бүрэлдэхүүнт цөм өгүүлбэрийг ялган зурж тэмдэглээрэй. (2 оноо)

.....
.....
.....

8. **Үхэр тэртээх нугад идээшилнэ. Тэр зүг цэцгэн дундуур дэгдэхүйеэ, хөлийн улнаас гижиг хүрч юу юугүй л чанга чангаар инээмээр болмуй** гэсэн өгүүлбэрээс орны утгатай үгийн жишээ нэгийг олж утга, үүргийг нь тайлбарлаарай. (2 оноо)

.....
.....
.....
.....

9. Эхээс уран дүрслэлийн жишээ нэгийг олж юуг юутай адилтгасныг тайлбарлаарай. (2 оноо)

.....
.....
.....
.....
.....

Гуравдугаар хэсэг: Эх зохион найруулж бичих

Хүүрнэмж эх зохион найруулж бичээрэй. (үгийн тоо – 100) (16 оноо)

10.“Цэцэгсийн хувилбар” өгүүллэгт байгалийн сайхныг дүрсэлж, хүний амьдралын явдлыг өгүүлжээ. Эхийг бичсэн арга хэлбэрийг дуурайн, өөртөө тохиолдсон болсон явдлын талаар хүүрнэмж эх найруулж бичээрэй.

Эхлэл хэсэгт - Өөрийнхөө очиж үзсэн, сэтгэлд хоногшсон газрын байгалийн сайхныг дүрслэн бичнэ.

Гол хэсэгт – Өөрт тохиолдсон болсон үйл явдлыг сонирхолтойгоор өрнүүлэн бичнэ

Төгсгөл хэсэгт – Та нарт ямар шинэ санаа, мэдрэмж, сэтгэгдэл төрж байснаа дүгнэж бичээрэй.

Хүүрнэмж эх зохион найруулж бичих даалгаврыг үнэлэх шалгуур

чиглэл	шалгуур	үнэлгээ	оноо
зорилго	Сэдэв,зорилго	Сэдэв,зорилгод нийцсэн	2 оноо
	бүтэц	Эхлэл, гол, төгсгөл хэсэг тус бүрийг гаргаж бичсэн эсэх	3 оноо
	Эш, баримт	Үг хэллэг, дүрслэх хэрэглүүр, жишээ, баримт ашиглаж бичсэн эсэх	2 оноо
	Хэв маяг	Бичлэгийн хэлбэр төрөл	1 оноо
Хэл найруулга	Үг, өгүүлбэр бүтэц	Үг сонголт оновчтой, өгүүлбэрийн бүтэц сайтай байх	2 оноо
	Хэл зүйн найруулга	Хэл зүйн алдаагүй, найруулга сайтай байх	2 оноо
	Үгийн тоо	Үгийн тоондоо багтаасан	1 оноо
Бичгийн соёл	ЗБД	Зөв бичгийн дүрмийн алдаа, үгийн үндэс буруу бичсэн зэргийг тооцох	2 оноо
	Бичгийн хэв	Бичгийн хэв соёлыг үнэлэх	1 оноо

Дөрөвдүгээр хэсэг: Үндэсний бичиг

1. Монгол бичгийн эхийг уншаад, зөв хэсгийг олж тэмдэглээрэй. (2 оноо)

1. Монголчууд бол олон мянган жилийн үеэс үндэснийхээ шинж төрхийг хадагалсан, уламжилалт зан үйл, ур ухаанаа эдэ хэрэглэл, ахуйн соёлдоо шингээн, хойч үедээ өвлүүлсээр иржээ. Энэ уламжлал нь дархны урлалаас тодорхой харагдана.

2. Монголчууд эрт үеэс үндэснийхээ шинж төрхийг хадгалсан, уламжилалт зан үйл, ур ухаанаа эд хэрэглэл, ахуйн соёлдоо шингээн өвлүүлсээр иржээ. Энэ уламжлал нь дархны урлалаас тодорхой харагдана.

3. Монголчууд эрт үеэс үндэснийхээ шинж төрхийг хадгалсан, уламжилалт зан үйл, ур ухаанаа эд хэрэглэл, ахуйн соёлдоо шингээн, хойч үедээ өвлүүлсээр иржээ. Энэ уламжлал нь дархны урлалаас тодорхой харагдана.

**7 дугаар ангийн монгол хэл, бичиг, уран зохиолын
анги дэвших шалгалтын блупринт**

ТМТ	энгийн түвшин		ТМТ		бүтээх түвшин	
	сэргээн санах	хэрэглэх	задлан шинжлэх	үнэлэх	бүтээх	нийт
уншиж ойлгох чадварын түвшин, хэлний зүй						
үг	1	2				3
өгүүлбэр		1	1			2
эх		1	2	1		4
бичих чадварын түвшинд					1	1
үндэсний бичиг	1	1				2
нийт	10%	40%	30%	10%	10%	100%

Анги дэвших шалгалтын жишиг даалгавар

Хичээлийн нэр: Монгол хэл бичиг, уран зохиол

Анги: 7 дугаар анги

Хугацаа: 60 минут

Нийт – 42 оноо

Эхийг уншиж ойлгоод, даалгаврыг гүйцэтгэнэ үү.

Жирх

Гэнэт миний ард өвс шажигнах чимээ гарлаа. Эргээд харвал бяцхан жирх ерхөгний толгой тас татан өмөр өмөр идэж суух аж. Жирх самрын чинээ буурцгийг урд 2 хөлөөрөө хавчаад шар шархийтэл хазалж өмөр өмөр иднэ. Буурцагны цаанаас ам нь үл харагдана. Мөн ч жижигхэн амтай амьтан юм даа. Ийм амьтан энэ их хүж ой тайга бүрхсэн ерхгийг хэчнээн удаан идээд юухан хороох вэ. Би жирхийг үргээхээс болгоомжлон бараг зүрхээ чагнаж суулаа.

Хэн ч зүрхэлж цочоомооргүй эгдүүтэй хөөрхөн амьтан бол энэ жирх юм байна. Ийм амгалан амьтантай зүүний сүвэгч үзэгдэх ойрхон ингэж тааралдана гэдэг аз гэж би баярлаж өдөржин энд суусан ч яахав гэж бодов.

Жирхийг үгээр зурна гэвэл яг онон дүрслэхэд бэрх юм. Мойл шиг хар мөртлөө оч шиг гялалзсан нүдтэй юм. Нарны туяанд очин хар нүд нь хааяа гялс гялсхийн цавчирна. Буурцаг хавчсан хоёр хөл нь богинохон мөртлөө овоо бахим, үлгэрлэвээс мариатай хүүхдийн чигчий хуруу гэмээр өхөөрдөм. Зурамных шиг эрэн урт сүүл нь шарласан навч дунд сагсалзана. Хэл мэддэгсэн бол уулын толгойд цасанд дарагдсаныг чи харж байна уу? Хүнсээ базаасан биз гэж түүнээс асуумаар байлаа.

Гэвч жирх намайг ганцхан дуугарвал л үргээд талийна байлгүй. Би сүүдрээ ч хөдөлгөхгүйг хичээж мөрөө хавчсан хэвээр суув. Жирх хэдэн буурцаг идээд нааш цааш гүйлээ. Тэгснээ бас нэг идэх юм олоод авлаа. Тэр нь түлээчний орхисон шинэ цавчис. Жирх цавчисны өчүүхэн өөдөс олж зуугаад бас л тар тархийтэл хэмэлж гарав.

Энэ үед пад падхийсэн чимээ гарч дэргэдэх хушнаас хэдэн боргоцой жирхний хажууд уналаа. Тэгмэгц жирх час час дуугараад цавчсаа зуусан хэвээрээ боргоцойноос бултах мэт гялалзан дэгдсээр ширэнгэ сүлжин алга болов. Жирхнээс юунд чингэж дэмий айв даа. Ажилсгаараа ой даяар цуутай сааралхан хэрэм л чамд боргоцой унагаж өгсөн шүү дээ.

Нэгдүгээр хэсэг: Унших

1. Үгсийн утгыг тайлбарлаарай. (3 оноо)

Үгс	Эхийн жишээ баримтаар холбон тайлбарлах	Үгсийн утгыг тайлбарлах
ерхөг		
буурцаг		
цавчис		

2. Эхээс сонин содон дүрслэлийн жишээ олж тайлбарлаарай. (2 оноо)

.....

.....

.....

.....

.....

.....

3. Эхээс жирхийн гадаад ба дотоод шинжийг тохирохыг хүснэгтэд нөхөж бичээрэй. (3 оноо)

дүрслэл	Гадаад шинж	дүрслэл	Дотоод шинж
нүүр царай		ааш зан	
бие галбир		онцлог чанар	
хувцаслалт		үзэл бодол	

алхаа гишгээ, үйлдэл хөдөлгөөн		яриа хөөрөө	
---	--	-------------	--

4. Эхээс төрсөн мэдрэмж, сэтгэгдлээ илэрхийлэн бичнэ үү. (3 оноо)

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

Хоёрдугаар хэсэг: Хэлний зүй

5. Эгшгийг гээж бичсэн үгийн жишээ эхээс хоёрыг олж, зөв бичгийн дүрмийг тайлбарлаарай. (2 оноо)

6. Хүснэгтэд тэмдэг нэрийн утгын ангилалд тохирох жишээ тус бүр нэг нэгийг эхээс олж бичээд тайлбарлаарай. (3 оноо)

№	тэмдэг нэрийн утгын ангилал	тэмдэг нэрийн жишээ	тайлбар
1	өнгө зүс		
2	шинж чанар		
3	хэлбэр		
4	хэмжээ		

7. Эхээс авиа дуурайх ба дүрс дуурайх үгийн жишээ тус бүр нэг нэгийг олж, хүснэгтэд тайлбарлан бичээрэй. (2 оноо)

Дуурайх үгс	авиа дуурайх ба дүрс дуурайх үгийн жишээ тус бүр нэг нэгийг олж бичээрэй
Авиа дуурайх
Дүрс дуурайх

8. Эхээс зэрэгцсэн нийлмэл өгүүлбэрийн жишээ олж бичээд, холбосон арга хэрэглүүрийг тайлбарлаарай. (2 оноо)

.....

9. Эхээс уран дүрслэлийн жишээ нэгийг олж юуг юутай адилтгасныг тайлбарлаарай. (2 оноо)

.....

Гуравдугаар хэсэг: Эх зохион найруулж бичих

Тоочимж эх зохион найруулж бичээрэй. (үгийн тоо – 100) (16 оноо)

10. “Жирх” эхэд амьтны гадаад, дотоод шинжийг дүрсэлжээ. Эхийг бичсэн арга хэлбэрийг дуурайн, өөрийнхөө дуртай амьтны тухай тоочимж эх найруулж бичээрэй.

Эхлэл хэсэгт - Өөрийнхөө дуртай амьтан, түүний амьдрах орчин зэргийг дүрслэн тоочиж бичнэ.

Гол хэсэгт – Сонгосон амьтныхаа өсөж торних тусам ямар их өөрчлөгдөж байсныг бичнэ

Төгсгөл хэсэгт – Та нарт ямар шинэ санаа, мэдрэмж, сэтгэгдэл төрж байснаа дүгнэж бичээрэй.

Тоочимж эх зохион найруулж бичих даалгаврыг үнэлэх шалгуур

чиглэл	шалгуур	үнэлгээ	оноо
зорилго	Сэдэв, зорилго	Сэдэв, зорилгод нийцсэн	2 оноо
	бүтэц	Эхлэл, гол, төгсгөл хэсэг тус бүрийг гаргаж бичсэн эсэх	3 оноо
	Эш, баримт	Үг хэллэг, дүрслэх хэрэглүүр, жишээ, баримт ашиглаж бичсэн эсэх	2 оноо
	Хэв маяг	Бичлэгийн хэлбэр төрөл	1 оноо
Хэл найруулга	Үг, өгүүлбэр бүтэц	Үг сонголт оновчтой, өгүүлбэрийн бүтэц сайтай байх	2 оноо
	Хэл зүйн найруулга	Хэл зүйн алдаагүй, найруулга сайтай байх	2 оноо
	Үгийн тоо	Үгийн тоондоо багтаасан	1 оноо
Бичгийн соёл	ЗБД	Зөв бичгийн дүрмийн алдаа, үгийн үндэс буруу бичсэн зэргийг тооцох	2 оноо
	Бичгийн хэв	Бичгийн хэв соёлыг үнэлэх	1 оноо

Дөрөвдүгээр хэсэг: Үндэсний бичиг

1. Дуудлага ижил, бичлэг өөр үгсийг зөв харгалзуулсныг олж, тэмдэглээрэй. (1.5 оноо)

1. Билиг оюун		а. ӨҮӨ
2. Бэлгэ тэмдэг	/	б. ӨҮӨ
3. Бэлэг дурсгал		в. ӨҮӨ

А. 1а, 2б, 3в Б. 1в, 2б, 3а В. 1б, 2в, 3а Г. 1б, 2а, 3в

2. “Хэн ч зүрхэлж цочоомооргүй эгдүүтэй хөөрхөн амьтан бол энэ жирх юм байна. Ийм амгалан амьтантай зүүний сүвэгч үзэгдэх ойрхон ингэж тааралдана гэдэг аз гэж би баярлаж өдөржин энд суусан ч яахав гэж бодов.” гэсэн өгүүлбэрийг үндэсний бичигт хөрвүүлээрэй. (2.5 оноо)

**8 дугаар ангийн монгол хэл, бичиг, уран зохиолын
анги дэвших шалгалтын блупринт**

ТМТ	ТМТ				бүтээх түвшин	
	энгийн түвшин	хэрэглэх	Задлан шинжлэх	үнэлэх	бүтээх	нийт
уншиж ойлгох, бичих чадварын түвшин, хэлний зүй	ойлгох, сэргээн санах					
үг	1	2				3
өгүүлбэр		1	1			2
эх	1	1	1	1		4
бичих чадварын түвшинд					1	1
Үндэсний бичиг	1	1				2
нийт	20%	40%	20%	10%	10%	100%

Анги дэвших шалгалтын жишиг даалгавар

Хичээлийн нэр: Монгол хэл бичиг, уран зохиол

Анги: 8 дугаар анги

Хугацаа: 60 минут

Нийт – 45 оноо

Эхийг уншиж ойлгоод, даалгаврыг гүйцэтгэнэ үү.

Модны эмч

Тоншуул мод тоншиж, амьдардгийг уншигчид маань андахгүй байх. Хүмүүс ойн эмч ч гэж нэрлэдэг. Түүний хараа сонсгол сайн хөгжсөн гэж хэлж болно. Өвчилсөн өттэй модонд хацраа наан чагнасаар байгаад өт хаана байгааг яг олно. Тэгээд цүүц маягийн гурвалжин урт хошуугаараа гаднаас нь тоншиж цоолон хошуугаа шургуулан оруулж өтийг хэлээрээ сугалан гаргаж ирдэг аж. Хэл нь 10-12 см урт нарийхан наалдамхай. Хошуу нь багтахгүй юм уу, хүрэхгүй нүхэнд байгаа шавжийг нарийн өвс мөчрийн хугархайгаар хатгаж барьж авна. Ойн эмчийг ахархан настай амьтан гэдэг. Үүнийг цаг үргэлж мод тоншиж тархиа доргиож байдагтай холбон тайлбарладаг. Тэр голдоо нүхтэй хуурай модыг цүүцдэн ухаж жилд нэг үүр засна. Үүрний ёроолд өд сөд, өвс дэвсэхгүй. Модон шалан дээр ангаахай нь торнидог. Хөлийнх нь уланд хатуу эвэр ургуулах гэж буй нь тэр. Яагаад гэвэл тэр том болоод бас л ургаа модноос хөлөөрөө дүүжлээстэй амьтан болох билээ. Гэвч энэ шувуу хойтон жил нь үүрээ дахиж ашигладаггүй. Бусад шувуунуудад “яг хийсэн ясан гэр” олдож бөөн баяр хөөр болдог байлгүй. Тоншуул гол тэвээргээ модны өт, авгалдайнаас авдаг боловч бусад шавж, аалз ялааг ч их хэмжээгээр идэж устгана. Харин өвлийн улиралд ургамлын үр, модны боргоцойгоор хооллоно. Самар цөмөх нь их онцлог.

Тэр модонд дандаа босоо байрлалтай байгаад сурчихсан байдаг тул газарт тэгшхэн суугаад тоншиж чадахаа больчихжээ. Газарт байгаа боргоцойг заавал модонд хавчуулж байж цөмж эхэлдэг аж.

Тоншуулыг хөх бух дагамтгай. Тоншуул тэрнийг ер хөөхгүй. Харин ч бүүр дуртай. Юу л олдono хагасыг нь тэр муу өөдөсхөн шувуунд хаяж өгдөг гээч. Яагаад ингэж хөл алдаад байна вэ гэвэл ийм учиртай.

Тоншуул мод тоншиж байхдаа хойноо юу болж байгааг мэддэггүй. Хэрэв харцага ирвэл яахав. Харцага ар шил рүү цоо тоншин унагаж мэднэ. Харин хөх бух байвал санаа зоволтгүй. Хөх бух түгшүүрийн дохио өгч байдгаараа хашхирна. Тоншуул ч бушуухан амиа хоохойлох аргаа бодно. Найзын тус ийм сайхан. Тоншуул урт наслах болтугай. Яагаад гэвэл ой мод маань улам улам илааршина шүү дээ.

(Ж. Мягмарсүрэн “Унагаа зуусан хулан буюу амьтдын тухай өгүүллэгүүд” ном, УБ хот 2003 он, хуудас 39)

Нэгдүгээр хэсэг: Унших

1. Үгийн утгыг тайлбарлаарай. (3 оноо)

Утгыг тайлбарлах үгс	Үгийн утгыг тайлбарла
цүүц	
ахар	
тэвээрэг	

2. Эхээс сонин содон дүрслэлийн жишээ олж тайлбарлаарай. (2 оноо)

.....

.....

.....

.....

.....

.....

3. Эхээс учир шалтгааныг илэрхийлэх жишээг олж бичээрэй. (3 оноо)

Модон шалан дээр ангаахай нь торнидгийн учир шалтгаан	үр дагаврыг бичээрэй	эхээс тохирох жишээ бичиж холбон тайлбарлаарай

4. Тоншуулыг хөх бух дагамтгай. Тоншуул тэрнийг ер хөөхгүй. Харин ч бүүр дуртай. Юу л олдono хагасыг нь тэр муу өөдөсхөн шувуунд хаяж өгдөг гээч. Яагаад ингэж хөл алдаад байна вэ? учрыг эхийн жишээгээр батлан тайлбарлана уу. (2 оноо)

.....

.....

.....

.....

.....

.....

.....

5. Хүснэгтэд тохирох жишээ эхээс олж бичээд тайлбарлаарай. (3 оноо)

	эхээс тохирох жишээ	тайлбар
дүрслэл		
баримт		
зохиогчийн үзэл бодол, дүгнэлт		

6. Эхээс төрсөн мэдрэмж, сэтгэгдэл, сургамжит санаа, ухаарч ойлгосон зүйлээ өөрийн үгээр үнэлж дүгнэж тайлбарлан бичээрэй. (4 оноо)

мэдрэмж сэтгэгдэл.....

сургамжит санаа.....

ухаарч ойлгосон зүйл.....

Хоёрдугаар хэсэг: Хэлний зүй

7. Эхээс зөв бичгийн дүрмээр бичсэн үгсийн жишээ тус бүр нэгийг олж бичнэ үү.(2 оноо)

Зөв бичгийн дүрэм	Эхээс тохирох жишээ	Зөв бичгийн дүрмийн тайлбар
Балархай эгшгийг гээж бичсэн		
Үйл үг бүтээх-л дагавар		

8. Холбох үгсийн утга, үүргийг тайлбарлана уу. (3 оноо)

Холбох үгс	Холбох үгсийн утга, үүргийг тайлбарла
тэгээд	
яагаад гэвэл	
гэвч	

9. **Тэр модонд дандаа босоо байрлалтай байгаад сурчихсан байдаг тул газарт тэгшхэн суугаад тоншиж чадахаа больчихжээ** гэсэн өгүүлбэрийг шалтгааны утгатай угсарсан нийлмэл өгүүлбэр болгож, шалтгааны утга илэрхийлж байгаа холбох хэрэглүүрийн утга, үүргийг тайлбарлана уу.(2 оноо)

Гуравдугаар хэсэг: Эх зохион найруулж бичих

Тайлбарламж эх зохион найруулж бичээрэй. (үгийн тоо – 100) (16 оноо)

10.“Модны эмч” эхэд байгальд тустай шувууны талаар дүрслэн тайлбарлажээ. Ямар нэг амьтан, ургамал болон хүний байгальд ээлтэй, ач тустай үйл ажиллагааны талаар тайлбарлаж бичээрэй.

Эхийг бичсэн арга хэлбэрийг дуурайн, тайлбарламж эх найруулж бичээрэй.

Эхлэл хэсэгт - Ямар нэг амьтан болон хүний байгальд ээлтэй, ач тус үзүүлсэн зүйлийн талаар мэдээлэн, тайлбарлаарай.

Гол хэсэгт – Тоншуул шиг байгальд тустай зүйл хийж болох талаар жишээ гарган тайлбарлаж бичнэ

Төгсгөл хэсэгт – Та нарт ямар шинэ санаа, мэдрэмж, сэтгэгдэл төрж байснаа дүгнэж бичээрэй.

Тайлбарламж эх зохион найруулж бичих даалгаврыг үнэлэх шалгуур

чиглэл	шалгуур	үнэлгээ	оноо
зорилго	Сэдэв,зорилго	Сэдэв,зорилгод нийцсэн	2 оноо
	бүтэц	Эхлэл, гол, төгсгөл хэсэг тус бүрийг гаргаж бичсэн эсэх	3 оноо
	Эш, баримт	Үг хэллэг, дүрслэх хэрэглүүр, жишээ, баримт ашиглаж бичсэн эсэх	2 оноо
	Хэв маяг	Бичлэгийн хэлбэр төрөл	1 оноо
Хэл найруулга	Үг, өгүүлбэр бүтэц	Үг сонголт оновчтой, өгүүлбэрийн бүтэц сайтай байх	2 оноо
	Хэл зүйн найруулга	Хэл зүйн алдаагүй, найруулга сайтай байх	2 оноо
	Үгийн тоо	Үгийн тоондоо багтаасан	1 оноо
Бичгийн соёл	ЗБД	Зөв бичгийн дүрмийн алдаа, үгийн үндэс буруу бичсэн зэргийг тооцох	2 оноо
	Бичгийн хэв	Бичгийн хэв соёлыг үнэлэх	1 оноо

Дөрөвдүгээр хэсэг: Үндэсний бичиг

1. “Тоншуул мод тоншиж байхдаа хойноо юу болж байгааг мэддэггүй. Хэрэв харцага ирвэл яахав. Харцага ар шил рүү цоо тоншин унагаж мэднэ. Харин хөх бух байвал санаа зоволтгүй. Хөх бух түгшүүрийн дохио өгч байдгаараа хашхирна. Тоншуул ч бушуухан амиа хоохойлох аргаа бодно. Найзын тус ийм сайхан.” үндэсний бичигт хөрвүүлээрэй. (3 оноо)

2. Дүрс ялган бичих үгсийг тохирох утгатай нь харгалзуулаарай. (1 оноо)

1.

2.

3.

4.

5.

6.

а. Тэмцээн шүү

б. Эрт урьд

в. Тийм шүү

г. Урьд хожид

д. Шүү хужир

е. Урьд түрүүн

А. 1е, 2б, 3г, 4д, 5в, 6а

В. 1б, 2г, 3е, 4в, 5д, 6а

Б. 1г, 2б, 3е, 4в, 5а, 6д,

Г. 1е, 2г, 3б, 4д, 5а, 6в

**10 дугаар ангийн монгол хэл,бичиг, уран зохиолын
анги дэвших шалгалтын блупринт**

№	Ай	Танин мэдэхүйн түвшин			Нийт	
		Ойлгох	Задлан шинжлэх	Хэрэглэх	Тоо	Хувь
1	Эхийн утга	1	1		2	28%
2	Өгүүлбэрийн бүтэц		1		1	14%
3	Үндэсний бичиг	1	1	2	4	14%
4	Эхийн хэрэглээ			1	1	14%
5	Үгийн утга	1		1	1	28%
Даалгаврын тоо		3	3	4	9	100%
Хувь		28%	28%	43%	100%	



Анги дэвших шалгалтын жишиг даалгавар

Хичээлийн нэр: Монгол хэл бичиг, уран зохиол

Анги: 10 дугаар анги

Хугацаа: 60 минут

Нийт – 30 оноо

1. Д. Нямсүрэнгийн “Дөрвөн цаг” шүлэгт зохиолчийн мэдрэмж, сэтгэгдэл хэрхэн илэрснийг тайлбарлана уу? (4 оноо)

Хөх лонхон тогоруу дуугарах нь сайхан
Хөдөө цайдам борооших сайхан
Анирхан ахуйд цэцэг дохих сайхан
Аадрын өмнөх байдал сайхан.

Тооноор сар гэрэлтэх сайхан
Тогоотой сүүнд тусах сайхан
Шөнө орой гарах сайхан
Чөдөртэй морь тургилах сайхан.

Эх нутаг минь шүлэг шиг сайхан
Эх орон минь дуу шиг сайхан
Эргэх дөрвөн цагт амьд явах сайхан
Эрээнцавд бороо орох сайхан.

2. Шүлгээс уран дүрслэлийг ялган, утгыг тайлбарлаарай. (4 оноо)

3. Мэдээлж тайлбарласан эх болохыг 3 шинжээр батлаарай. (3 оноо)

Анимэ

Анимэ бол хүүхэлдэйн кино хийх Японд дэлгэрсэн арга. Анимэ-ээр хийсэн кино ихэнхдээ япон үзэгчдэд зориулсан байдаг учраас япончуудын соёлын өв, ёс заншлаас их оруулсан байдаг. Тухайлбал: Анимэ-ийн баатрууын том нүд нь япончуудын хувьд “дотоод сэтгэл рүү харах цонх” гэсэн ойлголтыг агуулдаг ажээ. Хүүхдэд зориулсан асар олон төрлийн бүтээл байдаг хэдий ч насанд хүрэгчдэд зориулсан сэдэв, агуулгатай кино бас байдаг. Орчин үеийн Анимэ-ийн эхлэл 1956 онд тавигдсан боловч Осами Тазуки “Муши” компанийг үүсгэн байгуулснаар 1961 онд жинхэнэ амжилтад хүрсэн юм. Тазука нь японы манга нэртэй орчин үеийн комиксийн үйлдвэрлэлд тэргүүлэх байр суурь эзэлдэг. (“Британника” нэвтэрхий толь)

4. Өгүүлбэрийн бүтцийг тодорхойлно уу. (4 оноо)

Тэр уул амьд бөгөөд түүн шиг жаргалтай нь ертөнцөд үгүй билээ. (С. У)

5. Жамухын дүрийг хөрөглөж бичээрэй. (7 оноо)

6. Үндэсний бичгээр уншаад, кириллээр алдаагүй буулгаарай. (3 оноо)

7. Зөв галиглаж бичээрэй. (2оноо)

ᠠᠨᠢᠮᠡ
ᠠᠨᠢᠮᠡ
ᠠᠨᠢᠮᠡ
ᠠᠨᠢᠮᠡ
ᠠᠨᠢᠮᠡ
ᠠᠨᠢᠮᠡ

ᠠᠨᠢᠮᠡ
ᠠᠨᠢᠮᠡ
ᠠᠨᠢᠮᠡ
ᠠᠨᠢᠮᠡ

8. Холбох эгшгийн дүрмээр бичсэн үгийг олоорой. (1 оноо)

A. ᠠᠨᠢᠮᠡ B. ᠠᠨᠢᠮᠡ C. ᠠᠨᠢᠮᠡ D. ᠠᠨᠢᠮᠡ E. ᠠᠨᠢᠮᠡ


9. Үндэсний бичгээр дүрс ялган бичээрэй. (2 оноо)

хав – нохой

хатуу
ид хав
дээл хав

анги дэвших шалгалтын блуприн

№	Ай	Танин мэдэхүйн түвшин			Нийт	
		Ойлгох	Задлан шинжлэх	Хэрэглэх	Тоо	Хувь
1	Эхийн утга	1	1		2	28%
2	Өгүүлбэрийн бүтэц		1		1	14%
3	Монгол бичиг	1	1	2	4	14%
4	Эхийн хэрэглээ			1	1	14%
5	Үгийн утга	1		1	2	28%
Даалгаврын тоо		2	2	3	10	100%
Хувь		28%	28%	43%	100%	



Анги дэвших шалгалтын жишиг даалгавар

Хичээлийн нэр: Монгол хэл бичиг, уран зохиол

Анги: 11 дүгээр анги

Хугацаа: 60 минут

Нийт – 30 оноо

1.Галидас “Үүлэн зардас” зохиолд сэрэмж алдсан нэгэн ягшас хугацаатай цөлөгдөн алс хол суухдаа ард үлдсэн үзэсгэлэнт гэргийгээ санан, умар зүг нүүх үүлэнд хандан сэтгэлийн үгээ хэлүүлэхээр элч болгон илгээж байгаа билээ. Зохиолын дараах хэсгээс үүлний дайран өнгөрөх байгалийн гоо сайхныг зохиолч хэрхэн мэдэрч байгаа, тэр нь ямар үгээр илэрч байгааг тайлбарлана уу. (4 оноо)

Үүлэн зардас

Ойн гөрөөчний гэргий оршигч байшинт тэр уулнаа түдээд
Уснаасаа хөнгөлөн асгаж, цаашлан замнахад чинь,
Уруудаж Виндья уулнаа Нармадын гол мурилзах нь,
Уран зураачийн будсан зааны нурууны хээ мэт амуу.

Тааж байна би: сайн мэдээ хүргэхийг яаравч,
Таатай цэцэг анхилсан ууланд түдэн саатаж,
Тогос шувуу баярын нулимс унаган донгодон тосоход,
Түдэл үгүй хагацан салж үл чадам заа, чи

2.Дээрх хэсгээс уран дүрслэлийг түүж, утгыг тайлбарла. (2 оноо)

3.Эхийг эрдэм шинжилгээний хялбаршуулсан эх болохыг 3 шинжээр батлаарай. (3 оноо)

Загасны цусны эргэлт

Зүрх нь ховдол, тосгуур гэсэн хоёр үндсэн тасалгаатай. Түүний зүрхний ховдлоос цус артерийн судсаар урсан загалмайд очиж, хийн солилцоо явуулна. Ийнхүү хүчилтөрөгчөөр баяжсан цус загалмайгаас гарч бүх биеийг цусаар ханган, хүчилтөрөгч зэрэг шаардлагатай зүйлсийг тээвэрлэн хүргэсний дараа нүүрсхүчлийн хийтэй цус болон хувирч, венийн судсаар зүрхний тосгуурт цутгана. Ийнхүү загас цусны нэг эргэлттэй. Үүнийг цусны дан эргэлтийн тогтолцоо гэнэ. (*“Биологи XI” Уб., 2017 хуудас*)

